



“Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК
Дархан-Уул аймаг, Дархан сум, 16-р баг,
Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр ХХК,
206 тоот өрөө
Утас/факс: 7509-0044
Вэбсайт: www.dmp.mn

**“Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК-д шаардлагатай
шууд худалдан авалтын зар**

Батлагдсан төсөвт өртөг: 19,800,000 төгрөг

2025.09.05

№	Бараа ажил, үйлчилгээний нэр	ХН	Тоо хэмжээ
1	Төмөртэйн төмрийн ордын хүдрийн гарал үүслийн судалгаа (петрографи, минераграфийн судалгаа)	багц	1

**“ТӨМӨРТЭЙ ОРДЫН ХҮДРИЙН ГАРАЛ ҮҮСЛИЙН СУДАЛГААНЫ АЖИЛ”
ГҮЙЦЭТГҮҮЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР**

1	ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	
1.1	Талбайн байршил:	“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн эзэмшил бүхий Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт Төмөртэй орд
1.2	Судлагдсан байдал:	Ордын хэмжээнд эрлийн шатны ажлыг 1979-1980 онд, эрэл-үнэлгээний ажлыг 1981 онд, урьдчилсан хайгуулыг 1981-1984 онд, нарийвчилсан хайгуул ажлыг 1990-1994 онд, ашиглалтын үеийн хайгуулыг 2023 онд тус тус хийсэн.
1.3	Талбайн хэмжээ:	Төмөртэй уурхайн MV-013319 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийн 1199.84 га талбайг хамарна. Судалгааны ажил гүйцэтгэх талбайн байршлын зургийг хавсаргав (хавсралт зураг-1).
1.4	Ажлын шаардлага:	2025 оны худалдан авалт хийгдэх төлөвлөгөөт ажилд тусгагдсан ажил
1.5	Ажлын зорилго, хийгдэх ажлууд, гарах үр дүн:	
1.5.1	Ажлын зорилго,	Төмөртэй ордын хүдэр агуулагч чулуулгийн нас тогтоох цацраг идэвхт изотопын болон хүдэр үүсгэгч уусмалын эх үүсвэр, хүдрийн гарал үүслийн төрлийг тодорхойлох тогтвортой изотопын судалгаануудыг хийснээр төмрийн хүдрийн үүссэн геологийн орчин нөхцөл, хүдрийн гарал үүслийг тодорхойлж, цаашдын хайгуул болон ашиглалтын үйл ажиллагаанд чухал мэдээлэлтэй болно.

1.5.2.1	Хийгдэх ажлууд,	Минералогийн судалгаа: ордын агуулагч чулуулгийн нас тогтоох цацраг идэвхт изотопын болон тогтвортой изотопын судалгааны эрдсүүдийн монофракцыг ялгах микроскопын судалгаа
1.5.2.2		Ордын агуулагч чулуулгийн нас тодорхойлох U-Pb үнэмлэхүй насны судалгаа: SHRIMP IIe, LA-ICPMS багажуудаар
1.5.2.3		O болон/эсвэл Fe-ийн тогтвортой изотопын судалгаа: Continuous Flow (CF)-EA-IRMS эсвэл Mass Spectrometer (MAT 253 plus, Thermo Fisher Scientific) багажаар
1.5.3.1	Гарах үр дүн:	Ордын хэмжээнд тархсан хүдэр агуулагч чулуулгийн магмын, хувирмал, тунамал чулуулгуудын нас тодорхойлно.
1.5.3.2		Хүдрийн эрдсүүдийн изотопын шинж чанараас хүдэр үүсгэгч уусмал ба түүний эх үүсвэрийг тогтоох
1.5.3.3		Хүдэржилтийн явц дахь изотопын фракцжилтын процессыг ойлгох
1.5.3.4		Ордын гарал үүслийн төрлийг тогтоох (магмын, метасоматоз...г.м)
1.5.3.5		Ордын гарал үүслийг бусад ижил төстэй ордуудтай харьцуулалт хийж дүгнэлт гаргах
1.5.3.6		Геологийн судалгааны бусад ажлын үр дүнтэй нэгтгэн ордын хэмжээнд тархсан хүдэр, чулуулгийн геологийн орчин нөхцөл, онцлогийг тодорхойлж, түүнийг ашигт малтмалын гарал үүсэл, байршлын зүй тогтолтой холбон тодорхойлох
1.6	Тавигдах шаардлага:	Судалгааны ажил хийх хуулийн этгээд нь Монгол Улсад бүртгэлтэй байгууллага, аж ахуйн нэгж эсвэл хувь хүн байна. Үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй байх, Үүнд:
1.6.1		Гүйцэтгэгч талын голлох мэргэжилтэн нь геологич чиглэлээр их дээд сургууль төгссөн байх. Мэргэжлийн диплом, үнэмлэх, сертификаттай тухайн чиглэлээр 15-с дээш жил ажилласан туршлагатай байх. Монгол улсын зөвлөх геологич (инженер) байх
1.6.2		Ажил гүйцэтгэгч талын төслийн талбайд ажиллах мэргэжилтэн нь геологийн чиглэлээр тасралтгүй 15-аас доошгүй жил талбайн зураглал, эрэл хайгуул, шинжлэх ухааны академик чиглэлээр ажиллаж байсан ажлын туршлагатай байх
1.6.3		Төмрийн хүдрийн болон металлын төрлийн ордын геологийн тогтоц, хүдрийн гарал үүслийг тогтоох гол, сарнимал элементийн, цацраг идэвхит болон тогтвортой изотопын геохимийн төрөл бүрийн судалгаануудыг хийж, олон улсын импакт фактор бүхий сэтгүүлд нэгдүгээр эсвэл холбоо баригч зохиогчоор сүүлийн 5 жилд 1-оос доошгүй өгүүллэг хэвлүүлсэн байх;
1.6.4		Ажлыг гүйцэтгэх мэргэжлийн багт хүдрийн гарал үүслийн талаар судалгаа, шинжлэх ухааны зэрэг хамгаалж байсан, “Ашигт малтмалын орд судлал”-аар мэргэшсэн эсвэл зөвлөх зэрэгтэй геологич (инженер) багтсан байвал давуу талтай
1.6.5		Региональ болон дүүргийн металлогени, хүдрийн гарал үүсэл, тектоник структурын талаар өргөн ойлголт, мэдлэгтэй байх

1.6.6		Хээрийн боловсруулалт болон шинжилгээ, судалгаа, лабораторийн шинжилгээний үр дүн, мэдээллүүдийг хадгалах, боловсруулах компьютер, программ хангамжтай байх
1.6.7		Хүдрийн гарал үүслийн судалгааны ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай шинжилгээнд бэлдэх тоног, төхөөрөмж болон минералогийн судалгааны микроскоп, бусад үндсэн техник, багаж тоног төхөөрөмжүүдээр бүрэн хангагдсан байх, Өөрсдийн дээж бэлтгэх, шинжилгээ хийх лабораторитой бол давуу талтай. Монголд хийгддэггүй өндөр түвшний судалгааны багаж бүхий гадаадын их сургууль болон хүрээлэнгүүдтэй хамтын ажиллагааны гэрээтэй байх.
1.7	Техникийн шаардлага	Гүйцэтгэгч нь тухайн ажлыг гүйцэтгэхэд доор дурдсан болон эсвэл дүйцэхүйц техникийн шаардлагуудыг хангасан байх. Үүнд:
1.7.1		Хээрийн ажлын багаж: Нарийвчлал сайтай GPS төхөөрөмж, геологийн зориулалтын алх, компасс, геологийн хээрийн бусад зориулалтын багаж, хувцас, хэрэгсэл ашиглах
1.7.2		Олон төрлийн масштаб, судалгааны ажилд ашиглах геологи, геохими, геофизикийн, агаар, сансрын зураг, топо зураг ашиглах
1.7.3		Ажил гүйцэтгэгч нь хүдрийн судалгааны ажлыг одоо мөрдөгдөн хэрэглэж буй Монгол улсад болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт, арга аргачлалын дагуу гүйцэтгэх шаардлагатай. Гүйцэтгэгч нь дээр дурдсанаас илүү үр дүнтэй, оновчтой арга аргачлалыг захиалагчид санал болгож болох ба захиалагч талтай харилцан зөвшилцөж өөр аргачлал ашиглаж болно.
1.7.4		Анхдагч баримт материалын фото зургийг авахдаа өндөр нягтралтай фото зургийн камер ашиглах
1.7.5		Ажил гүйцэтгэгч нь ажлын даалгаварт тусгагдсан ажлуудыг бие даан гүйцэтгэнэ.
1.8	Судалгааны ажлын хөтөлбөр:	Хүдрийн гарал үүслийн судалгааны ажлын хүрээнд зайлшгүй хийж гүйцэтгэх ажлууд /үүгээр хязгаарлагдахгүй/
1.8.1		Өмнөх судалгааны ажлуудыг судлах;
1.8.2		Хээрийн ажлын үе шатанд шаардлагатай дээж, сорьцуудыг цуглуулах, дээж бэлтгэл
1.8.3		Лаборатори, Суурин боловсруулалт
1.9	Цаашид хийгдэх ажлын зөвлөмж, дүгнэлт:	Ордын хүдрийн гарал үүслийг тогтоосноор хүдрийн биетийн үргэлжлэл, тархалтын цар хүрээ, хэтийн төлөвийн талаар дүгнэлт өгч, цаашид хийгдэх ашиглалт, хайгуулын ажилд зөвлөмж хүргүүлнэ
1.10	ХАБЭА-н зааварчилгаа:	Ил уурхайд ажиллахдаа Төмөртэйн ил уурхайн ХАБ инженерээс уурхайн бүсэд нэвтрэх зааварчилгаа авч ажлыг эхлүүлнэ.
1.10.1		Өдөр тутмын ажлын заавар, ХАБЭА-н дүрэм, журам, зааварчилгааг ажил гүйцэтгэгч компани бүрэн хариуцна.
1.11	Хууль, журам, стандарт:	Ашигт малтмалын тухай хууль
1.11.1		Монгол Улсад мөрдөгдөж буй хууль дүрэм, журам холбогдох стандартууд

1.11.2		Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль
1.12	Үр дүнгийн тайланг хүлээлгэж өгөх:	Гүйцэтгэсэн ажлын дараалал, үр дүн, график, нарийвчилсан тооцоо, дүгнэлт, аргачлалыг тусгасан бичвэр тайлан, судалгааны ажлын санал, дүгнэлт, зөвлөмжийг Монгол хэл дээр 3% боловсруулж Захиалагч талд хүлээлгэж өгнө.
1.12.1		Хүдрийн гарал үүслийн судалгааны ажлын боловсруулалт хийсэн үр дүнгийн үндсэн өгөгдөл, зургуудыг файл хэлбэрээр захиалагч талд хүлээлгэн өгөх.
1.12.2		Судалгааны ажлын тайлан, дүгнэлт, зөвлөмжүүдийн бичиг баримтын бүрдүүлэлт, бичвэр нь олон улс болон Монгол улсад мөрдөгдөж буй стандарт, дүрэм журмын шаардлагад нийцүүлэн гүйцэтгэнэ.
1.13	Хавсралт мэдээлэл:	MV-013319 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Төмөртэй ордын байршлын зураг
1.13.1		Агаар сансрын зураг
1.13.2		Шаардлагатай мэдээллийг гүйцэтгэгч захиалагчтай зөвшилцөж авч болно
1.14	Ажлынхяналт, шалгалт.	
1.14.1		Гэрээт ажлын гүйцэтгэлд захиалагч талаас хүлээн зөвшөөрч баталсан календарчилсан төлөвлөгөө, холбогдох гэрээ болон техникийн даалгаврын дагуу хяналтыг тавина. Захиалагч нь шаардлагатай үед хэдийд ч гүйцэтгэгчийн хээрийн болон суурин судалгааны ажлын явцтай танилцах эрхтэй ба ажлын гүйцэтгэлтэй холбоотойгоор нэмэлт мэдээ, мэдээлэл гаргуулж авах эрхтэй
1.14.2		Гүйцэтгэгч нь дараах байдлаар тайлан болон холбогдох мэдээллүүдийг боловсруулж, захиалагч талд хүлээлгэн өгөх ба шаардлагатай тохиолдолд захиалагч талын хүсэлтээр нэмэлт мэдээлэл шаардагдах, өөрчлөлт оруулах эрхтэй ба талууд харилцан зөвшилцөнө.
1.14.3		Дараах ерөнхий шаардлагуудыг тавьж байна. Үүнд: Долоо хоног бүрийн ажлын явцын мэдээ, хээрийн ажлын үед өдөр тутмын тайланд тухайн өдрийн ажлын төлөвлөлт, гүйцэтгэл, аюулгүй ажиллагааны мэдээ мөн хүндрэл бэрхшээлүүдийн талаар зайлшгүй тусгасан байх.
1.15	Урьдчилсан тайлан	Уг тайланд дараах мэдээллийг урьдчилсан байдлаар хүргүүлнэ.
1.15.1		Ажлын явцын болон завсрын боловсруулалтын зураг, схем, гарсан үр дүнгүүд
1.15.2		Холбогдох бүх төрлийн анхдагч өгөгдлүүд (ямар нэг засвар хийгдээгүй) электрон байдлаар
1.15.3		Үр дүнгийн тайлан. Бүх тайланг монгол хэл дээр гүйцэтгэнэ. Гүйцэтгэгч нь хэвлэмэл тайлан, зураг болон бусад холбогдох мэдээллүүдийг тус бүр 3 хувь, мөн файл хэлбэрээр захиалагчид хүргүүлнэ. Тайланг дараах бүтэцтэйгээр боловсруулна. Үүнд:

1.15.4		Өмнөх үг (хураангуй): Хүдрийн гарал үүслийн судалгааны ажлын үр дүнг тусгасан, ажлын голлох дүгнэлтүүд, томоохон үр дүн, цаашид ажил гүйцэтгэхэд анхаарах зөвлөмж, гэрээ, төлбөр, давагдашгүй хүчин зүйлс зэргийг багтаасан товч тайлан боловсруулна.
1.15.5		Тайлангийн агуулга: Үндсэн гарчгууд (бүлгүүд), дэд гарчгууд, гуравдугаар зэргийн гарчгууд (дэд хэсгүүд), хүснэгт, график, фото зураг, холбогдох хавсралтуудын жагсаалтуудын хуудасны дугаар гэх мэт.
1.15.6		Удиртгал: Төслийн талбайд хийгдсэн хүдрийн гарал үүслийн судалгааны ажил гүйцэтгэсэн арга аргачлал, үр дүн, ажлын хэмжээ, чанарын хяналттай холбоотой хийгдсэн ажлууд, онолын тайлбар, тухайн ажлын онцлог, үндэслэл, лаборатори, сорьц, минералоги, хүдэр агуулагч чулуулгийн нас тогтоох цацраг идэвхт изотопын, хүдэржилтийн гарал үүслийг тогтоох тогтвортой изотопыг судалгааны ажлын хэмжээ, ажлын параметр зэргийг товч тусгах
1.15.7		Судалгааны ажлын аргачлал, ажлын үе шат: Судалгааны талбайн хүдрийн үүссэн геологийн орчин, хүдэр агуулагч чулуулгийн нас, хүдрийн гарал үүслийг тогтоох судалгааны ажлын арга аргачлалууд, мэдээлэл боловсруулсан үе шатуудыг тодорхой тусгасан байна. Мөн холбогдох зураг хүснэгтүүдийг заавал оруулна.
1.15.8		Нарийвчилсан үр дүн, тайлал: Хүдрийн гарал үүслийн судалгааны үр дүнд үндэслэн дэлгэрэнгүй тайлан хийж Ажлын даалгаврын 1.5 дахь хэсэгт тусгасан үр дүнгүүдийг тусгах
1.15.9		Цаашид хийгдэх ажлын зөвлөмж: Одоогийн судалгааны үр дүнгийн дэлгэрэнгүй дүн шинжилгээ, хэлэлцэх асуудал, судалгааны ажил гүйцэтгэх явцад гарсан асуудлууд, ашиглалт, хайгуулын ажлын төлөвлөгөөнд өгөх зөвлөмж, үндэслэл зэргийг тусгасан байна.
1.15.10		Дүгнэлт: Хүдрийн гарал үүслийн судалгааны ажлаар гарсан үр дүнгүүдийг нэгтгэсэн байдлаар товч дүгнэх, цаашид авч хэрэгжүүлэх ажлын зөвлөмж зэргийг тусгасан байна.
1.15.11		Ашигласан материалын жагсаалт: Тайлан, үр дүн боловсруулахад ашигласан бүх төрлийн ном зохиол, аргачлал, нийтлэл, тайлан, диаграмм зэргийг дэлгэрэнгүй тусгасан байна.
1.15.12		Хавсралтууд: Ажлын гүйцэтгэх шатанд хийгдсэн бүх зураг. Баримт бүрдлийн зураг, үр дүнгийн зургууд, график, диаграмм, фото зураг гэх мэт захиалагчийн шаардсан бүх шатны материалуудыг хавсаргасан байх.
1.15.13		Холбогдох бүх шатны зурган болон тоон мэдээллүүдийг хүлээлгэн өгөх. Гүйцэтгэгч нь захиалагчид холбогдох зурган болон тоон мэдээллүүдийг хүлээлгэн өгөхдөө захиалагчийн ашигладаг программ хангамжуудын орчинд чөлөөтэй хөрвөх боломжтой байдлаар бэлтгэн хүргүүлнэ.
1.15.14		Гүйцэтгэгчийн бэлтгэсэн зургууд, зурагт тавигддаг бүх шаардлагыг хангасан байх (масштаб, таних тэмдэг, бусад холбогдох тэмдэглэгээ гэх мэт)
1.16	Нэмэлт мэдээлэл.	Захиалагч нь нэмэлт байдлаар хүлээн авах материалд өөрчлөлт оруулах эсэхийг харилцан зөвшилцөж шийднэ.

1.17	Ажил гүйцэтгэх хугацаа:	
1.17.1		Ажил гүйцэтгэх гэрээний буюу захиалагчийн зөвшөөрч баталсан календарчилсан төлөвлөгөөний дагуу эхэлнэ.
1.17.2		Гүйцэтгэгч нь ажлыг гүйцэтгэх календарчилсан төлөвлөгөөг урьдчилсан байдлаар бэлтгэж захиалагчид танилцуулна. Уг судалгааны ажил нь дараах үе шаттай байна. Үүнд:
1.17.3		Бэлтгэл ажил. Гүйцэтгэгч нь гэрээ байгуулагдсан өдрөөс хойш Календарчилсан төлөвлөгөөнд долоо хоног тутмын, урьдчилсан болон эцсийн үр дүнгийн тайлангийн хугацааг тусгасан байна. Захиалагч болон гүйцэтгэгч талууд харилцан зөвшилцөж нарийвчлан төлөвлөнө.
1.17.4		Хээрийн ажил. Календарчилсан төлөвлөгөөг эцсийн байдлаар баталсан өдрөөс хойш гэрээнд заагдсан хоногийн дотор хээрийн ажлыг эхлүүлнэ. Ажил гүйцэтгэх нийт хугацааг календарчилсан төлөвлөгөөнд тусгагдсан хугацаанаас хэтрүүлэхгүйгээр гүйцэтгэх ба гүйцэтгэгчийн боловсруулсан судалгааны ажлын календарчилсан төлөвлөгөөтэй уялдсан байна. Хээрийн ажлыг захиалагч болон гүйцэтгэгч талууд хамтарсан баг гаргаж тойм маршрут хийснээр эхлүүлнэ. Захиалагч талаас хээрийн ажилтай өдөр бүр танилцана. Хээрийн ажлыг энэхүү техникийн даалгаварт тусгасан арга аргачлал холбогдох шаардлагын дагуу гүйцэтгэх ба гүйцэтгэлийг хяналтыг Захиалагчийн төлөөлөгчид хээрийн ажлын талбайд нь шалгах ба шалгалт, хяналт гүйцэтгэх бүх нөхцөлийн гүйцэтгэгч саадгүй хангана.
1.17.5		Боловсруулалтын ажил. Суурин боловсруулалтын ажлыг хээрийн ажил дууссан өдрөөс хойш төлөвлөгөөт хоногийн дотор хийн гүйцэтгэж, урьдчилсан (завсрын) тайланг Захиалагчид хүргүүлнэ. Захиалагч тал урьдчилсан тайланг ажлын 3 хүртэлх хоногийн дотор хянан үзэж шийдвэрлэх ба шаардлага хангасан гэж үзсэн тохиолдолд баталгаажуулж хүлээн авна. Шаардлага хангаагүй буюу уг техникийн даалгаврын холбогдох шаардлагуудыг биелүүлээгүй гэж үзсэн тохиолдолд гүйцэтгэгч нь 7 хүртэлх хоногийн дотор алдааг засаж захиалагчид дахин хүргүүлнэ. Ингэснээр техникийн даалгавар мөн холбогдох журам шаардлагуудад нийцэж байгаа эсэхийг хянан үзэж, шаардлагад бүрэн нийцсэн гэж үзсэн тохиолдолд баталгаажуулж хүлээн авна.
1.18	Нөхцөл байдал:	Төмөртэйн ил уурхайд хийлгэхээр нэмэлт тодотголд төлөвлөн оруулж байна.
1.19	Хавсралт мэдээлэл:	Шаардлагатай мэдээллийг гүйцэтгэгч захиалагчтай зөвшилцөж авч болно.
1.20	Төсөв өртөг: т	Төмөртэй ордын хүдрийн гарал үүслийн судалгааны ажил - 19,800,000 төгрөг
1.21	Эдийн засгийн үр ашгийн тооцоо, үнийн санал:	Шууд худалдан авалт тул үнийн саналыг авч ажлыг эхлүүлэх эрх үүснэ

Жич:

- **Урьдчилгаа төлбөр олгохгүй**
- **Төлбөрийг бараа нийлүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор төлнө.**

Бүрдүүлж ирэх материал:

- **Албан бичиг /Үнийн санал, ажил гүйцэтгэх хугацаа, төлбөрийн нөхцөлийг дурдсан байх/**
- **Байгууллагын гэрчилгээ, НӨАТ-ын гэрчилгээ, Татварын өргүй тухай тодорхойлолт**
- **Ажлын даалгавар, танилцуулга, бусад нотлох баримт**
- **Хариуцах этгээдийн итгэмжлэл, холбогдох мэйл, утасны дугаар**

**Үнийн санал хүлээн авах сүүлийн хугацаа:
2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 17 цаг 00 минут хүртэл**

Шүүд худалдан авалттай холбоотой тодруулга
болон үнийн санал хүлээн авах ажилтны
холбогдох хаяг: Худалдан авалтын хэлтэс
/procurement@dmp.mn/
Утас: 7509-0044